



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

ХҮН АМЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 5

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай:

1/1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хангасан иргэдийн одоо авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн нийлбэрийг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 30 хувиар нэмэгдүүлж, 1997 оны 1 дүгээр улиралд багтаан олгох;

2/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан иргэдэд одоо авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн хэмжээтэй тэнцэх "нөхөн олговор"-ыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд хөдөлмөр зохицуулалтын албадаар дамжуулан сар бүр олгох, тэдэнд дахин мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авах;

3/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан иргэдийн хөнгөлөлттэй тэтгэвэр болон нөхөн олговор авч байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгуулагч шимтгэл төлбөл зохих хувиар хөдөлмөрийн баталгаат хөлснөөс тооцож тэтгэврийн даатгалын санд төрөөс хариуцан үе шаттайгаар төлөх;

4/Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөр эрхлэлтийн тухай, Газрын дор болон хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөлд ажиллагчдын салбарын даатгалын тухай, Хувиараа хөдөлмөр эрхлэгч малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах тухай хуулиудын төслийг боловсруулж 1997 оны 4 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/Нийгмийн халамжийн талаар төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа, нийгмийн халамжийн санг эрхлэн зохион байгуулахдаа ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохицуулах.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,тэтгэмжийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг хангаагүйгээс тэтгэвэр нь зогсоогдсон иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх насандаа хүрч тэтгэвэр тогтоолгох, эсхүл нийгмийн халамжийн тэтгэвэр авах болсон тохиолдолд өндөр насны болон нийгмийн халамжийн тэтгэвэр ба нөхөн олговрын аль илүүг нь сонгон авах эрх олгосугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ